МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

АГУУЛГА

1 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2 ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН

3 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

4 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АРГА

5 ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

6 ТЕНДЕРТ ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

7 ОРОН НУТГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

37
НИЙТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ЗАСГИЙН ГАЗРААС БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛСАН

Журам, жишиг баримт бичиг	
Журам **9**	Жишиг баримт бичиг **9**

2006 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр УИХ-аар батлагдсан.

2011 Хуулийн нэмэлт, өөрчлөлт 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдөр УИХ-аар батлагдсан

2019 Хуулийн нэмэлт, өөрчлөлт 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр УИХ-аар батлагдсан

2023 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр УИХ-аар батлагдсан

ХУУЛИЙН 2011 ОНД ОРСОН ГОЛЛОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ӨМНӨ

1. Ерөнхий гэрээний тогтолцоогүй.
2. Чанар ба үнийн хосолсон үнэлгээ хязгаарлагдмал.
3. Гүйцэтгэлийн баталгааны уян хатан зохицуулалтгүй.
4. Мэргэжлийн төлөөлөл хангалтгүй.
5. Хариуцлагын тогтолцоо сул.
6. Төвлөрсөн худалдан авалтын тогтолцоогүй.
7. Үнэлгээний хугацаа урт.
8. Гэрээний мэдээллийн ил тод байдал хангалтгүй.

ӨӨРЧЛӨЛТ

1. **Ерөнхий гэрээний** арга нэвтрүүлэв.
2. Эм, эмнэлгийн хэрэгслийг **чанар ба үнийн хосолмол** аргаар үнэлэх зохицуулалт нэмэгдэв.
3. Урьдчилгаа төлбөрийн баталгаанд **гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулж тооцох** боломжтой болов.
4. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн **салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшил, эсхүл ТББ-ын хоёроос доошгүй төлөөлөл**, орон нутагт бол тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэн, ЗДТГ-ын ажилтан оролцуулахыг нэмсэн.
5. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий **улсын байцаагчийн чиг үүргийг** тодорхойлж тусгав.
6. Улсын төсвөөр санхүүжих төсөл, арга хэмжээг зохион байгуулах **мэргэжлийн байгууллага** байгуулагдав.
7. Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг **45 хоногт** багтаан зохион байгуулж дуусгах зохицуулалт тусгагдсан.
8. Худалдан авах ажиллагааг төсөв батлагдсанаас хойш **1 сарын дотор** хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэх болсон.

ҮР ДҮН

1. Байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг нэг ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч гэрээ байгуулан, бараг **цахим дэлгүүрт** байршуулж худалдан авах боломжтой болов.
2. **Эмийн чанарыг** тендерийн үнэлгээнд харгалзах болов.
3. Гүйцэтгэгчид үүсэх санхүүгийн **эрсдэл, ачааллыг бууруулсан**.
4. Худалдан авах ажиллагаа **ил тод** байдлыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналт тавих боломж бүрдсэн.
5. **Хуурамч** мэдээлэл ирүүлсэн, **гэрээний үүргээ биелүүлээгүй** оролцогчийг тендерт оролцох **эрхийг нь хязгаарлах** боломж бүрдэж, хариуцлага нэмэгдсэн.
6. Улсын болон бүс нутгийн шинжтэй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг **мэргэжлийн байгууллага зохион байгуулж**, яамдын ажлын **ачааллыг багасгаж**, үндсэн ажлаа хийх боломжийг бүрдүүлсэн.
7. Зарим томоохон тендер шалгаруулалтын эцсийн шийдвэр гарахгүй **200-300 өдөр** болдог байсныг зогсоосон.
8. Ил тод байдал нэмэгдэж, төлөвлөгөө нийтлэгдэх хугацаа **аж ахуй нэгжүүдэд тодорхой болсон**.

ХУУЛИЙН 2019 ОНД ОРСОН ГОЛЛОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ӨМНӨ

1. Цахим худалдан авах ажиллагааны тогтолцоо нэвтрээгүй.
2. Тендер шалгаруулалт цаасан хэлбэрт тулгуурласан.
3. Ногоон худалдан авах ажиллагааны зохицуулалтгүй.
4. Цахим худалдааны дэд бүтэц бүрдээгүй.
5. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих механизм дутмаг.

ӨӨРЧЛӨЛТ

1. Худалдан авах ажиллагааг **цахим системээр** зохион байгуулах эрх зүйн орчныг тодорхойлов. Цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах тухай журам батлагдав.
2. Цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах болсонтой холбоотойгоор **жишиг баримт бичгүүдийг шинэчлэн** батлав.
3. **Ногоон худалдан авах ажиллагааны** зохицуулалтууд тусгагдав. Техникийн тодорхойлолтыг шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байхаар боловсруулахаар заав.
4. **Цахим дэлгүүр,** түүнээс худалдан авалт хийхтэй холбоотой харилцааг тусгав.
5. **Дотоодын бараг импортын бараатай өрсөлдүүлэхгүй байх,** дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зохицуулалт бий болов.

ҮР ДҮН

1. Тендерт оролцоход олон байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах зэрэг баримт бичгийг **цахимаар** төлбөргүй авах боломжтой болж, **цаг хугацаа, санхүүгийн хэмнэлтийг** бий болгосон.
2. Оролцогч нар нэг төрлийн албан бичгийг олон дахин бичих, үүнтэй холбоотой үүсдэг хасагдах шалтгаан болдог **механик алдааг бууруулсан**. Тендерийн баталгаа, тендер илгээхтэй холбоотой гаргадаг олон албан бичгийг цахимаар **нэг маягтаар ирүүлэх** боломжийг бүрдүүлсэн.
3. Бараа, ажил, үйлчилгээнд **байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөл багатай** худалдан авалт хийх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
4. **Байнгын хэрэгцээтэй**, жил бүр тендер шалгаруулалт зарлан худалдан авдаг бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт бүртгэх, захиалагч **хугацаа алдахгүйгээр** худалдан авалт хийх эрх зүйн орчин бүрдсэн.
5. Засгийн газрын тогтоолоор батлагдсан Чанар стандартын шаардлага хангасан, тохирлын барааны жагсаалт батлагдсан. Уг жагсаалтад бүртгэлтэй бараг **импортын бараатай өрсөлдүүлэхгүй**гээр худалдан авах боломжтой болов.

ХУУЛИЙН 2019 ОНД ОРСОН ГОЛЛОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ӨМНӨ

1. Гомдол гаргах зохицуулалт хангалтгүй байсан нь худалдан авах ажиллагааг удаашруулах эрсдэлтэй байв.
2. Тендер шалгаруулалтын ил тод байдал хангалтгүй.
3. Өрсөлдөөнийг дэмжих нөхцөл хязгаарлагдмал.
4. Гомдол хянан шийдвэрлэх үйл ажиллагаа тодорхойгүй.
5. Тендерийн мэдээлэлтэй танилцах хугацаа богино.
6. Тендерийн үнэлгээний хугацаа урт.

ӨӨРЧЛӨЛТ

1. **Үндэслэлгүй гомдол** гаргасан оролцогчийн **тендерийн баталгааг улсын орлого болгох** зохицуулалт бий болж, шалгарсан оролцогчийн материалыг бусад оролцогч нарт ил болгох тухай журам батлагдав.
2. Тендерийн урилга, материал хүлээн авах, **үр дүнг** худалдан авах ажиллагааны **цахим системд нийтлэх** болов.
3. Харьцуулалтын аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтын **урилгыг цахим системд зарлаж**, үр дүнг цахим системээр **мэдээлэх** болов.
4. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх **журам батлагдав**.
5. Гэрээ байгуулах эрх олгож, ажлын 5-аас доошгүй өдрийн дараа гэрээ байгуулдаг байсныг ажлын 6-аас доошгүй өдөр болгов.
6. Тендер үнэлэх хугацааг бууруулж **15 хоног** болгов.

ҮР ДҮН

1. Тухайн тендерт шалгараагүй оролцогч нар шалгарсан оролцогчийн тендерийн материалтай танилцсанаар **үндэслэл бүхий гомдол гаргах** болсон ба тендер шалгаруулалтад тавих оролцогч нарын хяналт, ил тод байдал нэмэгдэв.
2. Худалдан авах ажиллагааны **ил тод байдлыг нэмэгдүүлсэн**.
3. Харьцуулалтын тендер шалгаруулалтыг 3-аас доошгүй аж ахуйн нэгжээс үнийн санал авч **шалгаруулдаг байсан тогтолцоог халж**, цахим системд урилга нийтэлдэг болгож, ил тод, **өрсөлдөх боломжийг нэмэгдүүлсэн**. Улмаар тендерийн материалтай танилцах, хяналт тавих, гомдол гаргах боломжтой болов.
4. Гомдлыг хүлээн авах, буцаах, хянан үзэх зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулав. Цахим системд бүртгэснээр оролцогч нар гомдол гарсан эсэх болон **гомдлын үр дүнтэй цаг алдахгүй танилцах** болов.
5. Шалгарсан оролцогчийн тендерийн материалтай бусад оролцогч нарын **танилцах хугацааг уртасгав**.
6. Тендер шалгаруулалтыг **хугацаа алдахгүй, шуурхай** зохион байгуулдаг болов.

ХУУЛИЙН 2022 ОНД ОРСОН ГОЛЛОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ӨМНӨ

1. Гэрээний хэрэгжилтийн эрсдэлийг уян хатан зохицуулах боломж хязгаарлагдмал.
2. Тендерийн баталгааны хэмжээ өндөр.
3. Гүйцэтгэлийн баталгааны шаардлага өндөр.
4. Тендерийн үнэлгээний хугацаа урт.
5. Тендерийн баталгааны хэлбэр хязгаарлагдмал.

ӨӨРЧЛӨЛТ

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэн баталсан бол захиалагч магадлалын дүгнэлтэд үндэслэн тухайн ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг нэмэгдүүлэн баталсан төсөвт өртөгт багтаан **нэг удаа өөрчилж** болно.
2. Тендерийн баталгааны дүнг **төсөвт өртгийн 0.5 хувь** болгов.
3. Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн **гурван хувиар тогтоож** тендерийн баримт бичигт тусгана.
4. Тендерийн үнэлгээг ажлын **15 өдрийн дотор** гүйцэтгэхээр тусгав.
5. Тендерийн баталгааг **Даатгалын баталгаагаар** гаргах боломжийг тусгав.

ҮР ДҮН

1. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хөл хорио, тээврийн асуудал болоод хөдөлмөрийн хөлс, бараа, материалын өртөг нэмэгдсэн. Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг **нэмэгдүүлэн баталсан** төсөвт өртөгт багтаан нэмэлт гэрээ байгуулах боломжтой болсон.
2. Цар тахалтай холбоотойгоор аж ахуй нэгжүүдийг дэмжих зорилгоор тендерийн баталгааны хувь хэмжээ бууруулж, тендерт оролцогч, гүйцэтгэгч нарын **санхүүгийн дарамтыг бууруулав**.
3. Цар тахалтай холбоотойгоор аж ахуй нэгжүүдийг дэмжих зорилгоор гүйцэтгэлийн баталгааны хэмжээг бууруулж, гүйцэтгэгч нарын **санхүүгийн дарамтыг бууруулав**.
4. Тендер үнэлэх хугацаа тендер хүчинтэй байх хугацаа буюу 30 хоног байсныг бууруулж, тендер шалгаруулалтын **үр дүнг шуурхай** гаргадаг байх боломж бүрдэв.
5. **Даатгалын компаниуд** тендерийн баталгаа гаргадаг болсон.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ

ТШ-ын зохион байгуулалт	2000–2007	2007–2012	2013–2016	2017–
Урилга нийтлэх	Өдөр тутмын сонин хэвлэлд	www.e-procurement.mn системд	www.meps.gov.mn системд	**www.tender.gov.mn цахим системд**
Тендерийн баримт бичиг авах	Захиалагчаас очиж худалдан авна	Захиалагчаас очиж худалдан авна	Захиалагчаас очиж худалдан авна	**Цахим системээс танилцаад ТШ-д орох бол системээр төлбөрөө хийнэ**
ТББ-ыг хүлээн авах	Оролцогч 2–3 хувь цаасаар бэлтгэж, дугтуйлан битүүмжлэн заасан газарт хүргэнэ	Оролцогч 2–3 хувь цаасаар бэлтгэж, дугтуйлан битүүмжлэн заасан газарт хүргэнэ	Оролцогч 2–3 хувь цаасаар бэлтгэж, дугтуйлан битүүмжлэн заасан газарт хүргэнэ	**ТББ-ийг системээр илгээнэ**
Баталгаа	Цаасаар ирүүлнэ	Цаасаар ирүүлнэ	Цаасаар ирүүлнэ	**Системээр ирүүлнэ**
Төлбөр	Бэлэн/Банкаар	Банкаар	Банкаар	**Системээр**
Нээлт	Оролцогчдыг байлцуулж нээлт хийнэ	Оролцогчдыг байлцуулж нээлт хийнэ	Оролцогчдыг байлцуулж нээлт хийнэ	**Цахим системээр**
Мэдэгдэл	Шуудангаар	Шуудангаар	Шуудангаар	**Цахим системд нийтэлнэ**
Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ	Цаасаар	Цаасаар	Цаасаар	**Цахим системд нийтэлнэ**
Гэрээний хэрэгжилт, үр дүн				**Цахим системд нийтэлнэ**

ТӨЛӨВЛӨЛТ

САНХҮҮЖИЛТ

Санхүүжилтийн эх үүсвэр батлагдана

ЗАХИАЛАГЧ

Төсөл, арга хэмжээгээр худалдан авах ажиллагааг төлөвлөнө

ДЭЭД ШАТНЫ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ

Захиалагчийн төлөвлөгөөг нэгтгэн хянана

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

Баталгаажуулж, худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлнэ.

Санхүүжилт батлагдснаас хойш 1 сарын дотор төлөвлөгөөг (www.tender.gov.mn)-д нийтэлнэ.

Сангийн яам	**БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ**
Захиалагч, үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн	**ДОТООД ХЯНАЛТ**
Оролцогч, Сангийн яам, Төрийн аудит, АТГ, шүүх болон бусад хууль хяналтын байгууллага	**ХЯНАЛТ**
Захиалагч	**ХЭРЭГЖИЛТ**

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

50 ба түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани

Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч

Худалдан авах ажиллагааг энэ хуулийн дагуу зохион байгуулахаар хуульд заасан бусад этгээд

ТАЙЛАГНАЛТ

ЗАХИАЛАГЧ

Төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрээр тайлагнана

ДЭЭД ШАТНЫ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ

Захиалагчийн тайланг нэгтгэн хянана

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

Төвлөрүүлэн захирагч болон захиалагчийн тайланг нэгтгэн хянана


САНГИЙН ЯАМ

Төсвийн ерөнхийлөн захирагчдын тайланг нэгтгэн хянана

Дараа оны эхний улиралд Засгийн газарт тайлагнана.

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2006-2026 ОН





“Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем /PIMIS/”-ийг 2023 оноос бүрэн нэвтрүүлсэнтэй холбогдуулан мөн үеэс хэрэгжүүлж эхэлсэн төслүүдийн санхүүжилтийн мэдээлэл

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2020 – 2023

Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх

- **2023 : Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Концесс**
- **2024: Нийслэлийн төсөв**
- **2024: Эрдэнэт үйлдвэр – Боловсролын төсөл**
- **2026:** 21 аймаг, 9 дүүргийн төсөв, Гадаад зээл, тусламж

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

2024

ОРОН НУТГИЙН ТӨСӨЛ

2023 – 2026*

Төсвийн хөрөнгө оруулалтын удирлагын цахим систем

www.publicinvestment.gov.mn

- ✓ **Иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод цахим систем болон гар утасны аппликейшн**
- ✓ **9 дэд систем**
- ✓ **Төрийн 24 системтэй холбогдсон**

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

2024 – 2026*

СУМ, ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2026*

ИХ ӨГӨГДӨЛ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН БОЛОН ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД СИСТЕМ

төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ийг хөгжүүлж, их өгөгдөл болон хиймэл оюун ухааны хэрэглээг эрчимжүүлэх.

www.map.publicinvestment.gov.mn

- ✓ 2025: Боловсрол
- ✓ 2026: Эрчим хүч, эрүүл мэнд, соёл, зам

Тусламж

/Хүмүүнлэгийн, техникийн болон бусад тусламж/

2027*

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

ЦАХИМ СИСТЕМД СУУРИЛСАН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

Нээлттэй тендер шалгаруулалтын арга

- Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.
- Нээлттэй тендер шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулж болно.

Харьцуулалтын арга

- Цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулна.
- Харьцуулалтын аргаар худалдан авах бараа цахим каталогт бүртгэгдсэн байна.

Гэрээ шууд байгуулах арга

- Захиалагчаас үл хамаарах яаралтай нөхцөлийн үед тухайн салбарын аж ахуй эрхлэгч нартай хэлэлцээ хийж, тендер хүлээн авна.

Нэг үүсвэрээс худалдан авах арга

- Оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар болон зөвхөн үйлдвэрлэгчээс нь худалдан авах бол нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар зохион байгуулна.


Ерөнхий гэрээний арга

- Бараа, үйлчилгээнд 3 хүртэл жилийн хугацаатай ерөнхий гэрээ байгуулна.
- Нийлүүлэгчийн бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт нэгж үнээр байршуулж, захиалагч цахим дэлгүүрээс худалдан авна.

- захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;
- онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;
- шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

2006-2026 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ-2006-2023 он

86%

Нээлттэй тендер шалгаруулалт

12%

Онцгой журам

1%

Бусад журам

Он	НТШ	Онцгой журам	ЗӨВЛӨХ	ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО	Шууд худалдан авалт	Ерөнхий гэрээний журам	Нийт (тэрбум ₮)
2006	154.94	17.16	-	-	-	-	172.10
2007	278.49	230.61	-	-	-	-	509.09
2008	655.91	103.59	-	-	-	-	759.51
2009	255.97	49.03	-	-	-	-	305.01
2010	1,266.49	84.05	-	-	-	-	1,350.54
2011	963.39	123.07	-	-	-	-	1,086.47
2012	1,460.96	122.90	-	-	-	-	1,583.86
2013	1,213.73	451.67	-	-	-	-	1,665.40
2014	956.08	90.26	-	-	-	-	1,046.33
2015	676.24	189.11	-	-	7.21	-	872.57
2016	390.01	458.08	-	1.18	10.90	-	860.16
2017	420.26	172.85	41.31	0.03		-	634.45
2018	1,143.36	146.81	30.28	0.47	0.01	-	1,320.92
2019	4,208.88	578.75	54.21	0.40	0.07	-	4,842.30
2020	2,881.10	698.02	67.89	0.84	0.18	-	3,648.02
2021	6,851.16	538.19	119.87	0.21	0.06	1.46	7,647.23
2022	6,643.29	975.70	151.76	-	0.08	1.69	7,909.73
2023	8,725.58	418.45	117.87	0.32	0.02	2.69	9,474.51

Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn), худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланд тусгагдсан мэдээлэлд үндэслэв

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АРГА-2024-2026 он

95%

Нээлттэй тендер шалгаруулалт

3%

Харьцуулалт

Он	НТШ	Харьцуулалтын арга	Гэрээ шууд Байгуулах	Нэг эх үүсвэрээс худалдан авах	Шууд худалдан авалт	Ерөнхий гэрээ	Олон улсын гэрээ	Нийт (тэрбум ₮)
2024	13,136.58	408.60	5.82	16.64	0.03	0.49	306.76	13,874.93
2025	16,355.55	393.79	5.0	3.32	0.04	2.01	121.05	16,880.74
2026	9,382.01	342.65	7.6	1.6	0.02	0.42	68.19	9,802.5

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГЫН ХЭРЭГЖИЛТ



Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д бүртгэлтэй мэдээлэлд үндэслэв

ИЛ ТОД БАЙДАЛ

ИЛ ТОД МЭДЭЭЛЭЛ



- ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ
- ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ
- ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН ТОДРУУЛГА, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
- БУСАД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ
- ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
- ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ШИЙДВЭР
- ЗАХИАЛАГЧИЙН ШИЙДВЭР
- ШАЛГАРСАН КОМПАНИЙН ТЕНДЕРИЙН НУУЦЛААГҮЙ ХЭСЭГ, ТЕНДЕРТ ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГА
- ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
- ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ
- ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ ГАРГАХ


	ЗАХИАЛАГЧ 57 дугаар зүйл	МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР 58 дугаар зүйл	САНГИЙН ЯАМ 59 дугаар зүйл	ШҮҮХ 60 дугаар зүйл
Гомдол гаргах үндэслэл	Захиалагч тендер шалгаруулалттай холбоотой хуульд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл	Тендер шалгаруулалтын баримт бичиг өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзвэл	Захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, эсхүл захиалагч гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй бол	Гомдол хянан шийдвэрлэх байгууллага, улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл
Гомдол гаргах хугацаа	**5 ажлын өдөрт** зөрчлийг мэдсэнээс хойш	**5 ажлын өдрийн өмнө** тендер нээхээс өмнө; нээлттэйгээс бусад аргад **3 өдрийн өмнө**	**5 ажлын өдөрт** шийдвэр гарснаас, эсвэл хугацаа дууссанаас хойш	
Шийдвэрлэх хугацаа	**5 ажлын өдөрт** гомдлыг хүлээн авснаас хойш	**10 ажлын өдөрт** гомдлыг хүлээн авснаас хойш	**10 ажлын өдөрт** гомдлыг хүлээн авснаас хойш	

САНГИЙН ЯАМАНД ГАРГАСАН ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

ГОМДЛЫН СУДАЛГАА

2024 ОН	
2,178 гомдол хянан шийдвэрлэсэн	
Гомдол үндэслэлтэй 1,755	Гомдол үндэслэлгүй 423
9.4% Зарласан тендер шалгаруулалт/гомдол гарсан тендер шалгаруулалтын харьцаа	

2025 ОН	
2,284 гомдол хянан шийдвэрлэсэн	
Гомдол үндэслэлтэй 1,773	Гомдол үндэслэлгүй 511
10.0% Зарласан тендер шалгаруулалт/гомдол гарсан тендер шалгаруулалтын харьцаа	



ХАР ЖАГСААЛТ

ТЕНДЕРТ ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛД ХАМРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Тендерт оролцохдоо илт худал мэдээлэл ирүүлсэн

Гэрээний үүргээ биелүүлээгүй

Сүүлийн 3 жилийн хугацаанд авлигын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон

Тендерт оролцохдоо илт худал мэдээлэл ирүүлсэн:

- ✓ Хуурам баримт бичиг;
- ✓ Худал мэдүүлсэн тендер ирүүлсэн.

Гэрээний үүргээ биелүүлээгүй:

- ✓ Гэрээний үүргээ гүйцэтгээгүй;
- ✓ Гэрээний үүргээ гүйцэтгэхэд алдаа гаргасан;
- ✓ Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй.

Сүүлийн 3 жилийн хугацаанд авлигын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон:

- ✓ Авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон

Бүртгэлтэй хуулийн этгээд

112

Гэрээний үүргээ биелүүлээгүй	Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлсэн
74	38

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх ба аймаг, нийслэл, дүүрэгт худалдан авах ажиллагааны нэгжтэй байна.

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА


9 ДҮҮРЭГ

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР


21 АЙМАГ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ /21 АЙМАГ/

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ /ТОО/




ТӨСӨВТ ӨРТӨГ /тэрбум ₮/




Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д бүртгэлтэй мэдээлэлд үндэслэв

ЗАРЛАСАН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ /НИЙСЛЭЛ/

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТОО



ТӨСӨВТ ӨРТӨГ /тэрбум ₮/



Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д бүртгэлтэй мэдээлэлд үндэслэв

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ

2023

- НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ;
- **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ;**
- **ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ;**
- ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА;
- **ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ;**
- ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА;
- **ГОМДОЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ;**
- **БУСАД**

8 бүлэг, 62 зүйл, 583 хэсэг, заалт

2026 ▸ ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

- НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ;
- **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ;**
- ТЕНДЕР ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГАА;
- **ЗАХИАЛАГЧИЙН ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГАА;**
- **ГОМДОЛ ГАРГАХ, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА;**
- ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ, ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ;
- БУСАД

7 бүлэг, 68 зүйл, 907 хэсэг, заалт

- **БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ, ЧАНАРГҮЙ ХУДАЛДАН АВАЛТЫГ ШИЙДВЭРЛЭНЭ**
- **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ЗАРДАЛ ӨНДӨР**
- **ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА ӨНДӨР, ӨРСӨЛДӨӨН БАГА**
- **ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ ХАНГАЛТТАЙ БИШ**
- **ХУДАЛДАН АВАЛТЫН ШИЙДВЭРТ ХӨНДЛӨНГӨӨС НӨЛӨӨЛДӨГ**
- **ХУВИЙН ХЭВШИЛ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ**

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА!

